

Том болсон өдөр \дурсамж тэмдэглэл\

РТМУИС-ийн сэтгүүлчийн ангийн оюутан Г.Чимэдцогзол

Жил болгоны зун манайх гэдэг айл том багагүй их л завгүй хүмүүс явдаг сан. сааль сүү, хонь мал унаач хүүхдийн хоол унд гээд эдгээр ажлууд бүгд ээжийн толгой дээр ирнэ. харин морио үсэргэх, хөлсийг нь авах, уяа сойлгоо тааруулах гээд дуусаж дундрахгүй ажлууд аавын мэдэлд очно.

Дүү бид хоёр ч бас дутахааргүй их ажил хийнэ ээ. Бараг өөрсдөө дотор нь орчих шахам том шуудайг шажигнатал нь дуугаргаад л гол өгсөөд аргалд явна. Нөгөөдхөө дүүргэсэн ч юм байхгүй тал дунд нь хүргээд дийлэхгүй болохоор нь хажуу бөөрийг нь цоортол чирсээр гэрийн хаяанд их л ядарцгаасан хүмүүс ирнэ. Шуудай цооллоо гэж ээжид загнуулахгүйн тулд цоорсон талыг нь аль болох нуугаад л ихийг түүсэн гэж харагдуулах гээд шуудайнхаа амыг нэлээн дээш нь болгоод босгоод тавина. Тэгээд дөрвөлж рүү асгах үед юун аргал бууц аваачаад хийчихсэн юм шиг л болчихсон байна. Аргагүй шүү дээ хэдэн зун ч юм бүү мэд халуун наранд хөхөртлөө шаруулчихсан муухан аргалыг чирч явахаар хог болохгүй гээд ч яах вэ дээ. “Жижиг шээзгийгээ үрээд яв гэж хэлсэн биз тээр түлэх юм алга” гээд л ээж үглэж гарна. Харин аав “За хүүхдүүд аргал түүгээд өглөө өөр яах гэв” гэж өмөөрнө. Энэ үгийг сонсоод бид хоёр их л том зүйл хийсэн хүмүүс шиг шагай дэлгэн гэрийн сүүдэрт сууцгаадаг сан. Тэр жил аргал элбэг газар буусан болохоор аав тэгж хэлсэн байх. Түүнээс биш аргалгүй газар тэгж эрхэлнэ гэж байхгүй шүү дээ.

Явдаг дэлгүүр

Сумын наадам эхлэх дөхөж бүгд л дор бүрнээ дээл хувцсаа зэхэцгээнэ. Харин би ул нь нимгэрсэн улаан тавчикаа харан “Яаанаа энэ тавчиктай наадам дээр явж байгаад ноднин гэр цэцэрлэгт хамт явж байсан ариунаатай таарах вий дээ тэгвэл ч онигоо болно доо. Заа ерөөсөө л наадам үзэхээ больдог хэргээ. Саахалт айлуудын тугалыг өөрийнхөө тугалтайгаа хамт хараал байж байя. Тэгвэл надад наадмаас ирсэн хүмүүс их чихэр өгнө дөө” гээд одоогийнхоор бол их л хэрсүү алсын бодолтой хүүхэд саяхан хөлсөлж ирсэн хээр мориныхоо хөлд нь цус буулгахгүйн тулд хөтөлж явахдаа бодож байлаа. Зунжин үсэргээний морьдын давхианд хаашаа яаж салдаг нь мэдэгдэхээ байсан цагаан замаар бор фургон зүг алдалгүй манайхныг чиглэн ирж яваа харагдана. Энэ машиныг хэн бүхэн андахгүй. Манай сумд ганцхан байдаг машин. Яаралтай үед түргэний машин, яаманд ажил гарвал албаны машин, за тэгээд хаана л ямар хэрэг гарна саадгүй яваа очдог ганц унаа даа. Гэрийн гадаа ирэх бараанаар аавынхаа даллахыг хүлээн дахин дахин гэр лүүгээ харна. Баяраар л өмсдөг жинсэн өмдөө өмсөж байдгаараа гоёчихсон дүү минь гүйгээд ирэх нь тэр ээ. Бодвол намайг авх явах гэж ирсэн биз. Үсээ шалба норгоод норгосон тал руу нь нүүрнийх нь хир яг л хавар уул уруу цас хайлаад бор хоормог урсаж байгаа аятай болжээ. Чухамдаа бол сумын төвийн хүмүүс ирсэн гээд өөрийгөө гоёсон нь тэр байлаа. Чи чинь юу болоод гоёчихсон юм гэхэд сумаас дэлгүүр ирсэн тэгэхээр нь өмсчихлөө. Таныг морио сайн уяад хүрээд ир гэнэ зөндөө олон гоё юм байна лээ гээд бид хоёр морины уян зүг хөдөллөө. манайх морины уяагаа гэрээсээ их хол зайд барина. Энэ жил гэрийнхээ хойд хамар дээр морины шонгоо зоосон юм. Ер нь бол

салхины дээр талд барьдаг учраас ихэвчлэн өндөр газар шонгоо зооно. Харин энэ нь дүү бид хоёр өгсөх нь хэцүү ч гэр лүүгээ гүйхэд их зугаатай амар байдаг. Бид хоёр морио уяж аваад гэрийн зүг уралдсаар сая нэг гэрийнхээ хаяанд ирлээ. Би түрүүлсэн үгүй ээ би түрүүлсэн...

Ногоон сандал

Гурил будаа, ургамлын тос, элсэн чихэр, вонк саван гээд л ээж маань нөгөө л нэг авдаг хэдэн зүйлсээ тоочиж гарлаа. Том том цаастай чихрүүд хэчнээн өдөр ч халуун машинд явсан юм бэ дээ бүү мэд гадна тал нь үрчийсэн алимууд, томоос том цэнхэр эмээлтэй зааны зурагтай элсэн чихэр өрөөтэй харагдана. Харин миний нүдэнд нэг л зүйл маш тод харагдаж байсан юм. Нарийхан даруулгатай ногоон сандал. Үзүүр хэсэгтэй том цагаан цэцэгтэй, гялалзсан саатай их гоё юм аа. Яг л үлгэрт гардаг гүнжийн шаахай шиг. намайг бариад зогсож байхыг ээж хараад “Хүүе хүний юм битгий муухай болгочих миний охин гэртээ ороод галаа нэмж бай ээж нь чихэр аваад араас нь орно” гээд намайг ногоон сандалаас минь салгасан юм. Миний амьдралдаа харж байсан хамгийн гоё сандал. Түүний хажууд миний улаан тавчик бол юу ч биш. авах юм сан гэж их л бодсон боловч ээждээ хэлж зүрхлээгүй. Гэртээ ороод удаагүй байж байтал ногоон фургон гэрийн гаднаас хөдөлж байгаа нь сонсогдлоо. Тэр үед би бараг л уйлах шахсан юм.

Том болохгүй

Наадмын өдөр эхэллээ. Даага нас бүр эрт гэгээ оров уу үгүй юу уралдаад ирсэн болохоор хэний морь нэг орж хэний морь баян ходоод болсныг морь цоллох үеэр л дуулдаг уламжлалтай. Гэрийнхэн маань

бүгд л хувцсаа өмсөөд л хачин гоё хүмүүс боллоо. Ээж “Миний охин яагаад хувцсаа өмсөхгүй байгаа юм бэ? Хурдал явъя” гэхэд нь “Би ийм муухай таавчиктай яаж явах юм бээ би гэртээ үлдэнэ” гээд уурлаад суучихлаа. ээж “Тэгээд чиний ногоон сандаалыг би өмсөж явах болж байна уу?” Ногоон сандаал би чихэндээ ч итгэсэнгүй айн та сая юу гэсэн бэ хэний ямар ногоон сандал. “Ээж нь үзээд байсан сандаалыг нь авсан зунжин морь хөтөлж тугалын араас гүйгээд улаан таавчик нь бараг цоорох шахсан байна. Энэ зун тугал хариулсны чинь шан шүү” гээд ээж хөлийн авдраас ногоон сандаалыг минь гаргаж өглөө. Би чинь тэнгэрт нисэх нь холгүй бөөн баяр ногоон сандаалаа өмсөөд л мотоцикл дээрээ дөрвүүлээ суугаад явлаа. Айлын нандин охин болохоор аавынхаа урд сууж явдаг байлаа. Багийн наадам ч гэсэн хөл хөдөлгөөн нэлээн эрт эхэлжээ. Хүмүүс бүгд л миний сандал руу хараад байгаа юм шиг санагдаад л, би нэг л өөр том хүн шиг болчихсон юм шиг санагдаад л, үеийн хүүхдүүд хүртэл жаахан хүүхэд шиг санагдаж байгаа юм чинь. Тэгээд л хүүхнээ хоёулаа хамт тоглоё гэсэн хүүхдүүдтэй үгүй ээ би одоо жаахан хүүхэд биш гэж хэлэх нь холгүй их зан гаргаад л өмнө нь морь ирлээ гэдэг дуунаар хамгийн түрүүнд гүйдэг байсан хүүхэд чинь хойно хоцорч бөх хараад л өөртөө бол их л намба сууж байсан шиг байгаа юм. Харин нь орой нь хөл маань холгоод бүр цэврүү үсэрчихсэн, найзуудтайгаа ч тоглосон юм байхгүй томчуудын уйтгартай яриаг чагнаад л зунжин хөтөлсөн хээр морио ч харж чадалгүй гэртээ ирж байсан юм даа. Тэр өдрөөс хойш би ахиж ногоон сандлыг өмсөөгүй юм. Том болохыг ч хүсээгүй юм.

Одоо бодоход их зөв зүйлийг хүсээгүй өнгөрөөсөн юм шиг санагддаг. Одоо ч гэсэн ээжийнхээ өвөрт унтдаг жаахан охин шүү дээ.

Хүн бүрийн цаана хүүхэд насных нь томоогүй зан үргэлж байдаг харин амьдрах гэж явах үедээ түүнийгээ улам л дараад байдаг шиг санагддаг. Хамгийн жаргалтай хүн гэж ямар хүнийг хэлэх вэ гэвэл хүүхэд зангаа гээгээгүй хүнийг гэж хэлнэ.